**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ**
**ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 06 сарын 16 өдөр | Дугаар А/28 | Улаанбаатар хот

Авилгын эсрэг 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Авилгын эсрэг хуулийн 5, 6 дугаар зүйл, "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалт, Нийслэлийн засаг даргын тамгын газрын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 03/3109 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн засаг даргын 2022 оны А/147 дугаар захирамжаар батлагдсан "Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө" болон Институтийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлж боловсруулсан "Авилгын эсрэг 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хавсралтаар батлагсугай.

2. Энэ төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, биелэлтэд байнгын хяналт тавьж, үр дүнгийн эхний хагас жил, жилийн эцсийн тайланг Нийслэлийн засаг даргын тамгын газарт тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга (Л.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

3. Энэ төлөвлөгөөний биелэлтийг хангуулахад шаардагдах 800,000 (найман зуун мянга) төгрөгийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу, Институтийн 2022 оны үйл ажиллагааны бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (О.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага санхүүгийн хэлтсийн дарга (Л.Эрдэнэбат)-д даалгасугай.

ДАРГА С.ОЧИР-ЭРДЭНЭ

ТУ31925 9070310718 5369568

3150600207

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байна;<br>- Хувийн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл тухай бүр бөглүүлсэн байна. | Жилдээ | - | - | аянд нэгдсэн байх;<br>Хувийн хэвшилтэй байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байх.<br>Хувийн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл бөглүүлсэн байна | ЗУСХ, ЭБАТ |
| 22 | Авлига, ашиг сонирхлын зөрчил, үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ г.м/ | Жилдээ | - | - | Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байна. | ЗУСХ, ЭБАТ |
| 23 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах | Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;<br>Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4;<br>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах; | Жилдээ | - | - | Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэсэн байна. | ЗУСХ, ЭБАТ |